



ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2017 оны 01 сарын 03 өдөр

Дугаар 04

Есөнбулаг сум

Төрийн дээд шагналд өргөн мэдүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.8 дахь заалтыг үндэслэн ТОГТООХ нь:

1. Монгол Улсын ардчилсан шинэ Үндсэн хууль батлагдсаны 25 жилийн ойг тохиолдуулан ажил хөдөлмөрийн амжилт бүтээл, аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэхэд оруулсан бодитой хувь нэмрийг өндрөөр үнэлж Гун-Аажавын Бааранг Монгол Улсын төрийн шагнал “Гавьяат эдийн засагч” цолоор шагнуулахаар Монгол Улсын Ерөнхийлөгчид өргөн мэдүүлсүгэй.

2. Төрийн дээд шагналд тодорхойлогдсон Г.Баарангийн тодорхойлолт, материалыг холбогдох журмын дагуу бүрдүүлж, Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газарт хүргүүлэхийг аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /А.Мөнхтөр/-д даалгасугай.



ДАРГА

Т.ГАНЗОРИГ